



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 11 сарын 18 өдөр

Дугаар А/337

Булган сум

“Бэрхшээлийг биш боломжийг харъя” сарын аян зохион байгуулахад хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.3, 42.1.6 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны XXV дугаар хуралдааны “Булган аймгийн 2024 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” XXV/05 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2024 оны “Хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээний зардлыг батлах тухай” А/633 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах өдрийг угтан аймгийн хэмжээнд зохион байгуулж буй “Бэрхшээлийг биш боломжийг харъя” сарын аяны хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардлыг хавсралтаар баталсугай.

2.Зардлын 6,280,000 (Зургаан сая хоёр зуун наян мянга) төгрөгийг Засаг даргын үйл ажиллагааны “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөрийн “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус салбар зөвлөлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх зардал”-аас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР

Аймгийн Засаг даргын 2024 оны
11 дүгээр сарын 18 ныг ний өдрийн 11 дугаар
захирамжийн хавсралт

“Бэрхшээлийг биш боломжийг харъя” сарын аяны
хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаанд шаардагдах зардал

Д/д	Зардлын төрөл	Тоо хэмжээ	Мөнгөн дүн	Нийт үнийн дүн
1	2	3	4	5
1	Монголын хараагүйчүүдийн үндэсний холбооны дэмжлэгтэй зохион байгуулсан урлагийн тоглолтод оролцогчийг байрлуулах зочид буудлын зардал	10 хоног	50.000	500.000
2	Булган сумын хөгжлийн бэрхшээлтэй, байнгын асаргаатай хүүхдэд гэрийн эргэлт хийх	56	80.000	4.480.000
3	АЗДТГ-ын гадаа үүдэнд тусламжийн хонх байрлуулах	1	300.000	300.000
4	“Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил, оролцоо” үндэсний чуулганд оролцогчдын байр, хоол, унааны зардалд дэмжлэг үзүүлэх	5	2.00.000	1.000.000
Нийт дүн				6.280.000